



САЙХАН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.АМАРЖАРГАЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgov@audit.gov.mn

2017. 02.14 № 01/04 ДУА-2017/101/СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Аймгийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Сайхан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аudit хийх явцад нийт 2,562,658.00 /Хоёр сая таван зуун жаран хоёр мянга зургаан зуун тавин наим/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ.

1. Сургуулийн захирал нь хяналт тавих албан тушаалыг буюу математикийн багшийн ажлыг хавсран гүйцэтгэж, 690,490.00 /Зургаан зуун ерөн мянга дөрвөн зуун ерөн/ төгрөгийн илүү цагийн хөлс авсан байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 28.1-д /...албан тушаалтайгаа ижил, эсхүл удирдах, хяналт тавих шинжстэй ажил, албан тушаалд ажиллахаар зэрэгцээн гэрээ буюу контракт байгуулахыг хориглоно/, 28.2-т /Энэ хуулийн 28.1 нь хавсран ажиллахад нэгэн адил хамаарна/, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 307/91/237 тушаалын хавсралт Цэцэрлэг ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журмын 23-т /Мэргэжлийн багшийг үндсэн ажилтуулар ажиллуулах бололцоогүй нөхцөл тэтгэвэрт гарсан, сургуулийн бус байгууллагад ажилласж байгаа болон ажилгүй байгаа мэргэжлийн багшийн ур чадварыг харгалзан хөлсөөр ажиллуулах гэрээгээр ажиллуулж цагийн хөлсийг нь үндсэн багшийн цалин хөлсний хэмжээнээс хэтрэхгүй байхаар тооцож болно/ заасныг тус тус зөрчсөн байна.

2. Сургалтын менежер хяналт тавих албан тушаалыг буюу өвчтэй, чөлөөтэй ажилтны үүргийг хавсран гүйцэтгэж, 1,191,318.00 төгрөгийн илүү цагийн хөлс авсан нь ажилтны цалинтай давхардаж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/ Хөдөлмөрийн тухай хуулийн 28.1-д /...албан тушаалтайгаа ижил, эсхүл удирдах, хяналт тавих шинжстэй ажил, албан тушаалд ажиллахаар зэрэгцээн гэрээ буюу контракт байгуулахыг хориглоно/, 28.2-т /Энэ хуулийн 28.1 нь хавсран ажиллахад нэгэн адил хамаарна/ заасныг тус тус зөрчсөн байна.

3. Ном хөтөлбөрийн хүрээнд тоног төхөөрөмж худалдан авахдаа анхан шатны баримтыг хуурамчаар бүрдүүлж 207,900.00 /Хоёр зуун долоон мянга есөн зуун/ төгрөгийг илүү шилжүүлж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4-т /хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх/, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т /батлагдсан тосов, хөтөлбөрийг

хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/ заасныг тус тус зөрчсөн байна.

4. Түлээ, нүүрсний хөнгөлөлт олгоходоо нийгмийн даатгалын шимтгэл дутуу тооцож 472,500.00 /Дөрөвнээ зуун даган хоёр мянга таван зуун/ төгрөгийг суутгаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32.1-т /Дараах хөдөлмөрийн холс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна/ 32.1.4-т /аж ахуйн нэгж, байгууллагаас ажсийтанд олгож байгаа хоол, унааны зардал, орон сууц, тулээ, нүүрсний унийн хөнгөлөлт, түүнтэй адилтгах бусад орлого/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.3 /Бусадаа өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолжс олгосон/, 3.1.7-д /Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан/ заасныг үндэслэн

ТОГТООХ нь:

1. Дээрх 2,090,158.00 төгрөгийг хавсралтад дурьдсан нэр бүхий албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100080000955 дугаар дансанд, дутуу тооцсон нийгмийн даатгалын шимтгэлийн 472,500.00 төгрөгийг холбогдох хүмүүсийн цалингаас суутган Ерөнхий боловсролын сургуулийн Төрийн сан банк дахь 100081215101 дугаар дансанд 2017 оны 03 дугаар сарын 01-ний дотор тус тус төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2017 оны 04 дугээр сарын 05-ны өдрийн дотор Аудитын газарт ирүүлэхийг Сайхан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Амаржаргал, нягтлан бодогч Г.Бум-Аюуш нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН¹:

ШИНЖСЭЭЧ

Ж.УГТАХБАЯР

НЯГТЛАН БОДОГЧ

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ

С.АМАРЖАРГАЛ

Г.БУМ-АЮУШ

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцааг албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.